



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠡᠶᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/556

Алтай хот

**Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2022
оны тооллогын ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2 дахь хэсэг, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх хэсэг, Соёлын өвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэр дээрх улс, аймгийн хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 9 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Үзлэг тооллогыг чанартай зохион байгуулж, тайланг аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (С.Цагаанбаатар)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 24 ны өдрийн 154 дугаар
Захирамжийн хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН 2022 ОНЫ ТООЛЛОГЫН АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2022 оны 08 дугаар сарын 24

Алтай хот

Ажлын хэсгийн ахлагч – С.Цагаанбаатар- Соёл, урлагийн газрын дарга

Гишүүд: С.Амгалан- Захиргаа, удирдлагийн хэлтсийн дарга

А.Сарантуяа- Соёл, урлагийн хэлтсийн дарга

Ц.Жамъяан– Захиргаа, удирдлагийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Баярзул- Соёл, урлагийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Элбэгзаяа- Соёл, урлагийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Жаргалсайхан- Соёл, урлагийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Баяндалай- Захиргаа, удирдлагийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Баярмаа- Архив, бичиг хэргийн эрхлэгч

Б.Гэрэлтуяа- Музейн эрдэм шинжилгээний ажилтан

Сумдын соёлын төвийн дарга нар

Сумдын газрын харилцаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Э.Өлзийдэлгэр- Соёл, урлагийн хэлтсийн соёлын өвийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

О.Нэргүй- Музейн бүртгэл мэдээллийн санч